

АРДЧИЛЛЫН III ЧУУЛГАН
“ЧӨЛӨӨТ, ХАРААТ БУС ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АРДЧИЛАЛ ДАХЬ ҮНЭ ЦЭНЭ”

Улаанбаатар хот, 2017 он 06 дугаар сарын 13

“ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ ДӨРӨВ ДЭХ ЗАСАГЛАЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ НЬ”
УИХ-ын гишүүн Лувсандангийн Болд

Хатагтай, ноёд оо,

Юуны өмнө Монголын ардчилал хүндхэн сорилттой тулгараад байгаа энэ цаг үед нэн чухал сэдвийн хүрээнд Ардчиллын чуулганыг зохион байгуулж байгаа Удирдлагын академи болон Конрад-Аденауэр-Сангийн хамт олонд талархал илэрхийлье. Нэн ялангуяа Монголын ардчиллыг өлгийтэй байх үеэс нь өнөөг хүртэл эгзэгтэй мөчүүдэд зөв зам голдрилд нь оруулахын төлөө хоёргүй сэтгэлээр тусалж дэмжиж ирсэн Конрад-Аденауэр-Санд талархаж буйгаа цохон тэмдэглэе.

Ардчиллын онцлог бол эрх мэдлийг нэг хүн эсвэл хэсэг бүлэгт төвлөрүүлэхийн оронд нийгмийн удирдлагыг хэрэгжүүлэгч засаглалын салаа мөчрүүдэд тараан хуваарилдаг явдал билээ. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн салаа мөчрүүд нь хоорондоо харилцан уялдаатай боловч хяналттай, тэнцвэртэйгээр бие даан оршиж байж энэхүү тогтолцоо үр дүнтэй байдаг.

Харамсалтай нь өнөөдөр манай нийгэмд энэхүү засаглал хоорондын зааг ялгаа бүдгэрч эрх баригч намын удирдах зөвлөл буюу хуучнаар улс төрийн товчоонд ихээхэн эрх мэдэл төвлөрөөд байгааг бид мэднэ. Сонгуулийн тогтолцооны сул талын улмаас ард түмний 50 хүрэхгүй хувийн санал авсан эрх баригч нам парламентад үнэмлэхүй олонхи болсон, парламентын гадна төдийгүй дотор сөрөг хүчнээ сонсох, харилцан зөвшилцөх улс төрийн соёл, сэдэл байхгүйн улмаас бид өнөөдөр тоталитар маягийн дэглэм рүү өдөр өдрөөр ойртож байна.

Чухам иймээс Монголын ардчиллыг цаашид авч үлдэхийн тулд төр засагт нийгмийн зүгээс хяналт тавих дуу хоолой, нүд, чих болсон хэвлэл мэдээлэл буюу “дөрөв дэх засаглал”-ын үүрэг хариуцлага нэн чухал болоод байна.

Хэвлэл мэдээлэл “дөрөв дэх засаглал”-ын үүргээ гүйцэтгэхийн тулд эрх чөлөөтэй байх ёстой. Тэгвэл манай хэвлэл мэдээллийн салбар өнөөдөр хэр зэрэг эрх чөлөөтэй байна вэ?

Хэвлэл мэдээлэл баттай хөгжиж, иргэний нийгэм, олон нийтийг мэдээллээр хангаж төр засгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргээ жинхэнэ ёсоор биелүүлж чадаж байна уу?

Монгол улс социалист лагерт багтах болсон цаг үетэй давхцан манайд сонин хэвлэл, радио телевиз үүсч хөгжсөн тул хэвлэл мэдээлэл анхнаасаа зөвхөн эрх баригч намын үзэл суртлын зэвсэг болж ирсэн, өөр үзэл бодол, мэдээлэл байлгадаггүй байлаа. Харин 1990 оны Ардчилсан хувьсгалын үр дүнд Монгол Улсад хэвлэл мэдээллийн эрх чөлөө сая бодит болж, иргэн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрхтэй болсон.

Тиймээс хэвлэл мэдээллийн эрх чөлөө гэдэг бол Монголын хувьд харьцангуй шинэ ойлголт юм. Манай хэвлэл мэдээллийн салбарынхан энэ эрх чөлөөгөө бататгахын төлөө ажиллаж, тэмцэж ирсэний үр дүнд өнгөрсөн 25 жилд бид хэвлэлийн эрх чөлөөний чиглэлд бодитой ололт амжилтыг олсон. Гэсэн хэдий ч бүх зүйл сайхан болчихоогүй төдийгүй зарим ноцтой ухралтууд ч гарах болжээ. Зарим баримтыг харцгаая.

2016 онд “Хил хязгааргүй сэтгүүлчид” (RSF) олон улсын байгууллагын гаргасан Хэвлэлийн эрх чөлөөний индексээр Монгол Улс дэлхийн 180 орноос 69 дүгээр байранд жагсаж, хэвлэлийн эрх чөлөөний “мэдэгдэхүйц асуудал”-тай орны тоонд багтсан байна. Мөн Freedom House байгууллагын судалгаагаар хэвлэлийн “хагас эрх чөлөөтэй” орон хэвээр байна.

Хэдхэн хоногийн өмнө иргэний нийгмийн байгууллагуудаас зохион байгуулсан хэвлэлийн эрх чөлөөний өдөрт зориулсан хэлэлцүүлэгт миний бие оролцсон юм. Тэрхүү хэлэлцүүлгийн үеэр нэгэн төлөөлөгч “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө бол хүчилтөрөгчтэй адил” гэж хэлснийг би тод санаж байна. Үнэхээр бид агаар мандал дахь хүчилтөрөгчөө байнга тэтгэж тэжээж байхгүй бол агаарын бохирдол мөнхийн аюул занал учруулсаар байх болно. Учир нь хаана эрх мэдэл төвлөрч байна, хаана ардчиллаас ухарч байна тэнд хэвлэлийн эрх чөлөөг боомилох “хэрэгцээ шаардлага” бий болдог. Сүүлийн үед Монголд төдийгүй дэлхий дахинд энэ эрх чөлөөнөөс “хумслах”, эсвэл энэ эрх чөлөөг гажуудуулж манипуляци хийх оролдлого тасралтгүй гарсаар байна.

“Глоб интернэшнл” төрийн бус байгууллагын үзэл бодлоо илэрхийлэх эрхийн зөрчилд хийсэн мониторингийн дүнгээр 2016 онд 61 сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хувь хүнд холбогдох, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг нь зөрчсөн нийт 63 тохиолдол бүртгэгджээ. Эдгээр зөрчил үйлдэгчийн 57.4 хувь нь улс төрч, төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллага ажээ. Энэ баримтаас хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд аюул учруулагчдын тэргүүн эгнээнд төр засаг болон улс төрийн албан тушаалтнууд байгааг харж болж байна.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд хэвлэл мэдээллийн салбарт холбогдох хууль тогтоомжид зарчмын өөрчлөлтүүд оржээ. Юуны өмнө төрийн ба албаны нууцын тухай хууль шинээр батлагдав. Энэ хуулиар төрийн болон албан нууц гэдгийг Засгийн газар өөрөө тодорхойлох эрхтэй болсноор мэдээлэл авах эрхийг эрх баригчдын зүгээс хааж боох нэгэн том боломж нээгдлээ гэж мэргэжилтнүүд дүгнэж байна.

Шинээр сонгогдсон УИХ 2016 оны 9 дүгээр сарын нэгнээс хүчин төгөлдөр болох ёстой байсан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийг хэрэгжилтийг хойшлуулж эдгээр хуулийг энэ онд дахин өөр байдлаар баталсныг бид мэднэ. Энэ хооронд хууль зүйн салбарын шинэчлэлийн олон чухал зорилт ухарч бүдгэрсний дээр шинэ хуулиудад хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хумиж дуу хоолойг нь хаах гэсэн хэд хэдэн оролдлого гарав.

Хамгийн сүүлийн жишээ гэвэл сэтгүүлчид, хэвлэлийнхэнд ялихгүй хэргээр эрүүгийн хэрэг үүсгэдэг явдлыг болиулж Зөрчлийн хуулиар зохицуулах гэсэн өмнөх парламентын үеийн санаачилгыг гуйвуулж дааж давшгүй мөнгөний дарамт тогтоох гэсэн оролдлого байлаа. Харин энэ оролдлогын эсрэг манай хэвлэл мэдээллийнхэн зохион

байгуулалттайгаар зоримог тэмцэн зогсоож чадсан нь жинхэнэ “дөрөв дэх засаглалын” хүчийг харуулсан явдал байлаа.

Өнгөрсөн хэдэн жилд хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд халтай энэ мэт хуулиуд гарсан боловч Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн шинэчилсэн найруулгын хэд хэдэн төслийг УИХ-аар хэлэлцэж баталсангүй өдий хүрлээ. Мөн миний бие бусад гишүүдийн хамтаар санаачлан боловсруулсан “Шүүмжлэгчийн эрхийг хамгаалах тухай” хууль энэ хаврын чуулганаар хэлэлцэх асуудалд орсон хэдий ч өнөөг хүртэл хүлээгдсээр байна.

Гэлээ гэхдээ хэвлэл мэдээллийн эрх чөлөө гэдэг бол нэг хууль гаргаад хүрчихдэг үр дүн биш байнгын баримтлах зарчим, хандлага байх учиртай. Нэн ялангуяа энэ салбарын эдийн засгийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь өнөөдрийн манай нийгмийг илүү эрүүл, тунгалаг болгоход чухал ач холбогдолтой юм.

Монголын зах зээл жижиг учир сэтгүүлчдийн ажлын үнэ цэнэ зохих ёсоор үнэлэгддэггүй, санхүүгийн бэрхшээл байнга учирдаг. Улмаар хэвлэл мэдээллийн ихэнхи хэрэгсэл цэвэр зах зээлийн зарчмаар биш аль нэг улс төрч, улс төрийн хүчний татаасаар оршин тогтнож байгаа нь нууц биш. 2010 онд батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харъяалал ил тод байх” заалт анх удаа тусгагдаж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэх зорилтууд тусгагдаж байжээ. Гэвч өнөөдөр хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн жинхэнэ эзэмшигчид хөшигний ардаас хөгжим захиалж нийгмийн сэтгэлзүйг удирдах мэдээллийн дайн хийсэн хэвээр. Сэтгүүлчид, редакциуд тэднээс хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн болон эдийн засгийн бодит орчин бүрдээгүй байна.

Иймд сэтгүүлчдийг санхүүгийн хувьд хэн нэгнээс хараат бус байлгах, сэтгүүлчид өөрсдөө ёс зүйн хэм хэмжээгээ ягштал баримтлах тийм нөхцөл бололцоог бүрдүүлэх ёстой. Монголын нөхцөлд хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчдийг дэмжих олон талт (multistakeholder) механизм хэрэгтэй гэж бодож байна. Жишээлбэл төр, хувийн хэвшил, иргэдийн ямар ч далд нөхцөлгүй (without strings), сайн дурын хандив дээр тулгуурласан сан хэлбэртэй байж болох юм. Ийм санаачилгыг төрөөс татварын бодлогоор дэмжих боломжтой. Энэ чиглэлээр туслалцаа дэмжлэг үзүүлдэг, илүү туршлагатай гадаадын мэргэжил нэгт нөхөд, олон улсын байгууллагуудтай манай сэтгүүлчид улам идэвхтэй хамтран ажиллах хэрэгтэй.

Монголын нийгэм ардчилсан тогтолцоонд шилжээд 27 жил болж буй нь багагүй хугацаа мэт боловч нийгмийн тодорхой институци бэхжин төлөвшихөд төдийлөн хангалттай хугацаа биш. Манай иргэдийн нийгмийн идэвх харьцангуй өндөр болсон боловч хэвлэл мэдээллээр өөрийгээ зөв илэрхийлэх соёл сайн сууж өгөөгүй байна. Бусдын бурууг шүүмжлэхийн зэрэгцээ тэдний үзэл бодол, нэр хүнд, хувь хүний нууцыг хүндэтгэх, бусдыг үзэн ядахаас татгалзах зэрэг тэнцвэртэй хандлагад суралцах шаардлага байна. Ийм ч учраас бид иргэний боловсрол, ардчиллын боловсролд анхаарал тавьж, НҮБ, ЮНЕСКО-гоор холбогдох тогтоол батлуулж ирлээ. Иргэний боловсрол, ардчиллын боловсролыг үр дүнтэй зохион байгуулах замаар иргэдийнхээ сэтгэлгээнд суурь

өөрчлөлт хийхэд дутуу анхаарч ирсэн явдал бидний нэг чухал сургамж юм.

Хэвлэлийн эрх чөлөөтэй холбоотойгоор хөндөх ёстой бас нэг чухал сэдэв бол Social Media буюу хэвлэл мэдээллийн шинэ чиг хандлагатай холбоотой асуудал юм. Facebook, Twitter зэрэг нь өнөөдөр найз нөхөд хоорондын нийгмийн сүлжээ төдий биш оролцоонд суурилсан нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нэгэнт болжээ. Үүнтэй холбоотойгоор цахим орчин дахь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, түүнтэй хамт яригдах учиртай хариуцлага, этикийн асуудлыг зөв зохицуулах шаардлага урган гарч байна. “Онлайн эрх чөлөө эвсэл”-ийг үүсгэн байгуулагчдын нэг, бүс нутагтаа интернэтийн хэрэглээ, чөлөөт байдлаар тэргүүлж буйн хувьд Монгол Улс энэ чиглэлээр олон улсын сайн үлгэр дуурайл болох боломжтой.

Саяхан би хэсэг гишүүдийн хамт УИХ дотор «Интернэтийн эрх чөлөөг дэмжигч бүлэг» байгуулсныг та бүхэн мэдэж байгаа болов уу. Энэ бол онлайн эрх чөлөөний үзэл санааг парламент дотор дэлгэрүүлэх, УИХ-аас гарч байгаа хууль тогтоомжид хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлахуйц заалт орохоос сэргийлэх, онлайн эрх чөлөөг хуульчлан бататгах зэрэг зорилготой санаачилга юм.

Үгийнхээ эхэнд хэлсэнчлэн манай сэтгүүлчид хэвлэл мэдээллийнхэнд өнөөдөр улам илүүтэй үүрэг хариуцлага ноогдсон цаг үе ирээд байна. Парламент сөрөг хүчингүй, байсан ч хэт нөлөө багатай байвал сөрөг хүчин парламентаас гадна талд гардаг. Өөрөөр хэлбэл хэвлэл мэдээлэл сөрөг хүчний үүргийг гүйцэтгэдэг. Ингэхээс ч өөр арга байхгүй. Сэтгүүлчид маань өнөөдөр ард түмнийгээ төлөөлсөн Их хурлын гишүүд гэж өөрсдийгөө бодох хэрэгтэй. Өнөөдөр эрх баригчид сонгогчдын 47 хувийг төлөөлж байгаа юм бол 53 хувийг төлөөлөх сөрөг хүчин нь бид юм гэж та бүхэн үзэх хэрэгтэй. Манай сэтгүүлчид үнэний төлөө, шударга ёсыг нийгмийн хэм хэмжээ болгохын төлөө, хэвлэлийн эрх чөлөөний төлөө тууштай тэмцэнэ гэдэгт эргэлзэхгүй байна. УИХ-ын гишүүний хувьд би энэхүү тэмцлийн галын шугаманд үргэлж хамт байх болно.

Анхаарал тавьсанд баярлалаа!